



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/329

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 15 дугаар тогтоол, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийн 7 дугаар бүлгийн 7.2 дахь зорилт, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Цагдаагийн газарт явуулын пост нийлүүлэх ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ц.Эрдэнэбат -(Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Б.Балдорж -(Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Г.Идэрхангай -(Цагдаагийн газрын нярав, дэд ахлагч)

Д.Адьяахүү -(“Хуку цамхаг” ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга:З.Жаргалтуяа-(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2.Барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Ц.Эрдэнэбат), цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг (А.Ержан)-т тус тус үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ